



**СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭГ ЯВЦЫН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, ЦААШИД
АНХААРАХ АСУУДЛУУД**

СТСХэлтсийн дарга Г.ЭНХТАЙВАН



СУМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Аймгийн засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсэг сумдад 2022 оны 10 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд ажилласан.

■ Өвөлжилтийн бэлтгэл ажил

■ Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажил:

- ▷ Хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн явц
- ▷ Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн явц
- ▷ Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц
- ▷ Аймгийн Засаг дарга, сумын засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн явц
- ▷ Хяналт шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцтай танилцлаа. Зөвлөн туслах ажлын явцад байгууллагын удирдлагууд болон төрийн албан хаагчдын боловсруулсан баримт бичигтэй танилцан харилцан ярилцаж цаашид анхаарах болон хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээнүүд дээр арга зүйн зөвлөмж өгсөн.



БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД



❖ Бодлогын баримт бичиг болон баталсан хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих гүйцэтгэлийн хяналт дутагдалтай.

❖ Хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн явцтай танилцахад 3 сум нь хагас жилийн байдлаар үр дүнг тооцсон 4 сум тайлан мэдээ гаргаагүй байна. 4 сум аймгийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөгөө гарган батлуулсан.

❖ Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцахад төлөвлөлтөө буруу хийсэн байна. Төсвийн байгууллагын дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.

❖ Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дагуу аймгийн сайтад мэдээллээ байршуулсан эсэх талаар үзэхэд Адаацаг, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Өндөршил сумд 80 хувьтай байршуулсан бусад сум нь огт байршуулаагүй байна.

❖ Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 8 сард явцын хяналт шинжилгээ хийгээд өгсөн зөвлөмжийг үзэхэд зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулж төлөвлөлт тайлагналтаа сайжруулсан сум байхгүй байна.

❖ Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцтай танилцахад Өндөршил сум өгсөн зөвлөмжийн эзэнжүүлсэн бусад сум нь ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байна.

❖ ХШҮ-ний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад удаашралтай хэрэгжүүлж байгаа заалтуудыг эрчимжүүлэх арга хэмжээ авах талаар чиглэл өгсөн.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД



Хөдөлмөрийн тухай(шинэчилсэн найруулга) хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан хэдий ч загварын дагуу байгуулаагүй байна.



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад туслах малчны ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг зохицуулан “Туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээ”-г танилцуулсан бөгөөд гэрээ байгуулсан сумд байхгүй



Эрх зүйн хөтөч нарын дунд зарласан болзолт уралдааны удирдамжийн дагуу зохион байгуулж буй үйл ажиллагаатай танилцахад уралдааны дагуу Дэлгэрхангай, Дэлгэрцогт Говь-Угтаал сум тусгай төлөвлөгөө гарган арга хэмжээ зохион байгуулсан санаачлагатай байна. Бусад сумд эрх зүйн хөтчийн тухайн жилийн төлөвлөгөө гаргасан түүнийхээ дагуу иргэдэд мэдээлэл түгээж байна.




Сумын ЗДТГ-ын Эрх бүхий албан тушаалтнууд (ЭБАТ)-ын дунд зарласан уралдаан удаашралтай. Иймд сумдын засаг дарга нар ЭБАТ-ын нэмэгдэл цалинг олгохдоо ажлын гүйцэтгэлийг харгалзаж олгох шаардлагатай.



Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 1, 2, 3 дугаар хавсралтын дагуу бүртгэлүүдийг үзэхэд Өндөршил сум хийсэн бусад сумд огт хийгээгүй байна.



Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хавсралтын бүртгэлүүдийг үзэхэд огт хийгдээгүй байна.





МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД



“Цахим албан хэрэг хөтлөлт ” аяны үйл ажиллагааны үр дүн хангалтгүй ирсэн бичгийн бүртгэлийг цахимаар хийсэн боловч гар хөтлөлттэй зөрүүтэй. Өлзийт сум гар хөтлөгөө байхгүй. Цахимаар 150-360 бичиг бүртгэсний хугацаатай бичгийн хоцролт нийт бичгийн 12-35 хувийг эзэлж байна.



Цахим цаг бүртгэлийг 4 сум, 3 сум нь гар бүртгэлээр хяналтаа тавьдаг хэдий ч ERP системийн цаг ашиглалтын тайлангаар цалинг олгодог сум байхгүй байна.



Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” операторын үйл ажиллагаатай танилцахад үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2-30 хүний лавлагаа гарган үйлчилсэн байна.



Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, бүртгэл, хяналт, шийдвэрлэлттэй танилцахад Өлзийт сум бүртгэлийн дэвтэргүй, бусад сумд нь бүртгэлийн дэвтэртэй боловч буруу бөглөсөн дутагдлууд байсан.



Цахим хуудасны хөтлөн удирдах эрх бүхий албан хаагчийн үйл ажиллагаатай танилцахад <https://www.dundgovi.gov.mn> цахим хуудасны “Орон нутгийн мэдээ” хэсэгт 0-7 мэдээ байршуулсан байгаа нь сумдын мэдээ оруулалт хангалтгүй байна. Мөн Энэ оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт төрийн албан хаагчид албан харилцаанд хувийн цахим шуудан ашиглахыг хориглосон тул тамгын газрын албан хаагчдын цахим хаяг ашиглалт хангалтгүй байна.



ӨГСХ –ийг цахимаар 3 сум, 4 сум нь цахимаар бүртгэл хийдэггүй мөн цахимаар бүртгэл хийсэн 3 сумын цахимын бүртгэл гар бүртгэл 2 зөрүүтэй байна. Санхүүгийн зарцуулалтын бүртгэл гэж огт байхгүй.





ᠳᠤᠨᠳᠦᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА. АЖИЛД НЬ
АМЖИЛТ ХҮСЬЕ.**



2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

人
 之
 所
 共
 知
 也



УСАН ХАНГАМЖИЙН ТАЛААР

НҮБ-ын Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянжаргалан, Дэлгэрхангай, Өлзийт, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдуудад гүн өрмийн 7 худаг, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг төсөл”-ийн санхүүжилтээр Дэрэн суманд инженерийн хийцтэй 1 худаг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай, сумдуудад инженерийн хийцтэй 17 худаг гаргаж ашиглалтанд оруулсан.



Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдууд 27 цооног гаргаж, Орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгөөр Баянжаргалан, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд 32 энгийн уурхайн худаг сэргээн засварлаж 110,0 мян/м² бэлчээрийн талбайг усжуулсан.



БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧИДТЭЙ ТЭМЦСЭН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 185-р тогтоол “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн Үлийн цагаан оготнотой тэмцэх тухай А/166 захирамжийн хүрээнд 2-р улиралд Адаацаг, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдууд энгийн механик аргаар 6,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцсэн. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянжаргалан, Луус, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд 4-р улиралд энгийн механик аргаар 12,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцэж 18,0 мянган/га бэлчээрийг сайжруулсан.





Дундговь аймаг
Засаг дарга
Тамгын газар

БЭЛЧЭЭР ХАШИЖ ХАМГААЛАХ БОЛОН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛАХ



Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу өвөлжөө, хаваржааны дэргэд Говь-Угтаал, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 21 малчин өрх 43,3 га талбайг нөөц бэлчээр болгон хашаажуулсан. Мөн Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Эрдэнэдалай сумдын 18 малчин өрх 9 га талбайд тэжээлийн ургамал тариалсан.



ОТОРЛОЛТЫН БАЙДАЛ

Булган, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Улаанбаатар, Төв, Хэнтий зэрэг аймгуудын нутагт 13 сумын 181 өрхийн 97961 толгой мал оторлож байна.

Оторлолт гол төлөв Говьсүмбэр аймгийн Баянтал, Төв аймгийн Баянжаргалан, Баян, Баян-Өнжүүл, Хэнтий аймгийн Галшар сумдуудад оторлож байна.

Мөн өөрийн аймаг дотроо 404 өрхийн 218594 толгой мал оторлож байна. Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан сумдуудад отор ихээр орсон байна.





ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАЛТ



2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 277 тогтоолын 3 заалт бүхий арга хэмжээний хэрэгжилт-100 хувь, Аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл хангах 03 албан даалгаврын 8 заалт бүхий арга хэмжээний хэрэгжилт 80 хувь, Мөн ХХААХҮСайдын 2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангах А/71 тушаалын хавсралт 10 хүснэгтийн дагуу доорх байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангагдсан.



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАЛТ

15 сумын 68 багийн нутагт 7670 малчин өрх, 842 мал бүхий өрхийн 3,8 сая толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 5,2 сая толгой мал өвөлжих төлөвтэй байна.

Өөр аймгийн нутагт-181 өрхийн 97961 мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт өвөлжих 404 өрхийн 218594 мал, Тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 28 өрхийн 31375 мал, отроор нийт 613 өрхийн 347930 тоо толгой мал оторлох төлөвтэй байна.

Малчдын бэлтгэл хангалт бүдүүн өвс-2162,2тн, үйлдвэрийн тэжээл-1970,7тн, гар тэжээл-5288,9тн, давс хужир шүү-2021,6тн 40,5 хувьтай бэлтгэл хангагдсан.

Бэлчээрийн талбайн хэмжээ 7,1 сая га, өвөл хаврын бэлчээрийн дундаж ургац 2,5цн, байгаа бөгөөд өвөлжих малын тоонд харьцуулсанаар 2,0 сая га бэлчээр нь өвөлжиж хаваржихад хэвийн, бэлчээрийн хүрэлцээ хангамж 37 хувьтай байна.

Байран тэжээлд орох 77424 мал хонин толгойд шилжүүлснээр 113015 толгой мал, нэмэгдэл тэжээлд оруулах 185191 толгой мал хонин толгойд шилжүүлснээр 263758 тоо толгой мал байна.





ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАЛТ


Аймаг сумдын Засаг дарга нарын аюулгүй нөөц өвс-974,4тн, тэжээл-365,7тн 93,4 хувьтай аюулгүй нөөц бүрдүүлсэн.

Өрхийн бэлтгэл хангалт малын тарга хүч-92,7 хувь, хашаа саравч-98,6 хувь, хоол хүнс дулаан хувцасны хангалт-93,5 хувь, түлээ түлшний нөөц-95,8 хувь, хүн мал эмнэлгийн эмийн сан-98,3 хувь, мал эмнэлгийн арга хэмжээ-94,6 хувь, малчин өрхийн бэлтгэл хангалт-94,1 хувьтай хангагдсан.

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангалт 86,3 хувьтай бэлтгэл хангагдсан.

Усан хангамж бэлчээрт инженерийн хийцтэй худаг-948, энгийн уурхайн худаг-2712, нийт уст цэгийн тоо-3660, ашиглахад бэлэн уст цэг 95,4 хувь, Усаар хангагдсан өрх 99,6 хувьтай байна.

Хашаа хорооны хангамж энэ онд шинээр бодын хашаа-15ш, богийн хашаа-44ш хашаатай болж бодын хашаа-606ш, богийн хашаа-5998ш хашаа хорооны хүрэлцээ хангамж 98,6 хувьтай хангагдсан.






ТӨВ СУУРИН ГАЗРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ

Аймгийн төв болон 11 сумын халаалтыг “Ган-Илч” ХХК, “Дундговь-Ус” ОНӨҮГ, “Тэвшийн говь” ХХК, “Ариунболор” ХХК, “Үлэмж хурд” ХХК, “Ирмүүн түшиг” ХХК, “Тадайма” ХХК, “Алтай авантур” ХХК, “Овл ский” ХХК, “Говь энерги илч” ХХК, “Хангай илч дулаан” ХХК гэсэн 1915 айл өрх, 136 төсвийн байгууллага, 146 аж ахуй нэгжүүдэд дулааныг үйлдвэрлэн хэрэглэгчдэд түгээдэг. Үүнээс гадна аймгийн төвд 9 төсвийн байгууллага, 30 аж ахуйн нэгжүүд цахилгаан болон өөрийн нам даралттай уурын зуухаар 63 барилгын дулааныг түгээж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч, ЭХЗЗ-ийн гишүүн, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн нартай хамтран Аймгийн төвд дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй “Ган-Илч” ХХК, “Дундговь-Ус” ОНӨҮГ, “Тэвшийн говь” ХХК, “Ариунболор” ХХК гэсэн 4 компаниуд 13 уурын зуухнуудаар 1 удаа 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалган зөвлөмж болон үүрэг даалгавар өгч ажиллалаа.





Дундговь аймгийн засаг даргын тамгын газар

“Ган-Илч” ХХК, “Тэвшийн говь” ХХК, “Ариунболор” ХХК, “Үлэмж хурд” ХХК, “Ирмүүн түшиг” ХХК, “Овл сай” ХХК, “Говь энерги илч” ХХК, “Тадайма” ХХК, “Хангай илч дулаан” ХХК нар 2019 оны 09-р сарын 28-29-ны өдөр, “Дундговь-Ус” ОНӨҮГ 2022 оны 09-р сарын 21-ны өдөр халуун усны уурын зуух, 2022 оны 9-р сарын 29-ны өдөр конторын уурын зуухны шугамны ус шахан 2022 оны 10-р сарын 1-ний өдөр халаалтыг түгээсэн.






2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын байдалтай ажлын хэсэг сумдаар ажилласан.

Аймгийн Засаг даргын 2022 оны 10-р сарын 17-ны өдрийн А/406 дугаар захирамжаар 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг байгуулан 2022 оны 10-р сарын 18-ны өдрөөс 2022 оны 10-р сарын 22-ны өдөр хүртэл 15 сумдын төв суурин газрын өвөлжилтийн ажлыг газар дээр нь шалгалаа.

Уг шалгалтаар Өндөршил сумын халаалтыг Ирмүүн түшиг ХХК 2018 оны 11 дүгээр сарын 09-нд эхэлсэн. Сумын 5 байгууллага, 7 объектыг халаадаг. Ирмүүн түшиг ХХК нь 2022 оны 10-р сарын 17-ны өдрийн байдлаар 20 тн нүүрс татан авсан. Хэмжих хэрэгсэлийг Стандарт хэмжил зүйн хэлтэсээр баталгаажуулаагүй. Цахилгаан тасрах үед эмнэлэг, ЗДТГ, банкууд цахилгааны нөөц мотортой уурын зуух байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 08-р сарын 17-ны өдрийн А/337 дүгээр захирамжаар 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг байгуулан 2022 оны 10-р сарын 18-ны өдрөөс 2022 оны 10-р сарын 22-ны өдөр хүртэл 15 сумдын төв суурин газрын өвөлжилтийн ажлыг газар дээр нь шалгалаа.





Цаашид анхаарах асуудал

Сайнцагаан сумын 17 а,б байранд оршин суудаг байгууллагын эзэмшлийн байранд байгаа хувь хүмүүсийн байрны төлбөр /халаалт, цэвэр ус/ -н асуудлыг шийдвэрлүүлэх.

Сайхан-Овоо сумыг халаалтаар хангадаг Ган-Илч ХХК-ийн шинээр тавьсан нөөц тогоог бүрэн угсрах, нүүрсний нөөц хийх шаардлагатай.



Тэвшийн говь ХХК халаалтын үнэ тариф нэмэгдсэн цаашид дулааныг тасралтгүй, стандартад нийцсэн дулаан үйлдвэрлэх шаардлагатай.

Хулд сум өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг сайжруулах шаардлагатай төв суурин газрын өвөлжилтийн 2 заалттай байсан.

Дэлгэрхангай сум хөдөө аж ахуй болон төв суурин газрын 2022-2023 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гаргаагүй. Өвөлжилтийн бэлтгэл ажил сумын хэмжээнд хийгдсэн байсан.

